



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/36

Мандалговь

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 8 дугаар зүйлийн 8.1.4 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалыг үндэслэн Захирамжлах нь:

1. Аймгийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Анхбаяр (Аймгийн засаг даргын орлогч)

Гишүүд: Н.Гантулга (Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын дарга)


С.Энхбат(Дундговь Цахилгаан Түгээх сүлжээ салбарын ерөнхий инженер)

Э.Болормаа (Авто Тээврийн Төвийн техник хяналтын үзлэгийн инженер)

Нарийн бичгийн дарга: Э.Азжаргал (Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга)

2. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг журмын дагуу зохион байгуулагч, тооллогын дүнг нэгтгэн цахим санд бүртгэн, Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Ус цаг уур орчны шинжилгээний газарт 2023 оны 03 дугаар сарын 01- ний өдөрт багтаан хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (М.Анхбаярт)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823110003